

ХУРААНГУЙ ДҮГНЭЛТ

Эдийн засгийн өсөлтийн хурд саарлаа. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэл сэргэж, үйлчилгээний салбарууд тэлсэн ч уул уурхай, тээвэр, барилга, худалдааны салбаруудын үйл ажиллагаа агшсанаар Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 2.4 хувьд хүрч удааширлаа. Эрэлт талаас эдийн засгийн өсөлтийг хөрөнгө оруулалт болон өрхийн хэрэглээний тэлэлт дэмжсэн ч экспорт болон төрийн хэрэглээний бууралт эдийн засгийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлээ. Ажиллах хүчний оролцооны түвшин 62 хувьд хүрч, нэрлэсэн орлого өссөн нь нийт өрхийн хэрэглээг дэмжсэн ч үнийн өсөлтийн нөлөөгөөр өрхийн бодит орлогын өсөлт саарлаа. Эдийн засгийн нийт үйлдвэрлэл потенциал түвшнээсээ 0.6 орчим хувиар доогуур байна.

Экспортын орлого буурч, урсгал дансны алдагдал нэмэгдлээ. Нүүрс, зэсийн баяжмал, төмрийн хүдэр зэрэг голлох уул уурхайн бүтээгдэхүүний экспортын биет хэмжээ өмнөх оны мөн үеийн түвшинд хадгалагдсан хэдий ч нүүрсний үнийн бууралтын голлох нөлөөгөөр экспортын орлого буурлаа. Хэдийгээр нийт импортын өсөлт саарсан ч экспорт буурснаар урсгал дансны алдагдал өмнөх оны мөн үеэс 1.8 дахин тэллээ. Гадаад валютын нөөц 2025 оны эхний улирлын эцэст 5.0 тэрбум ам.долларт хадгалагдсан ч төв банкны зах зээлд нийлүүлсэн гадаад валютын хэмжээ өмнөх оны мөн үеэс 0.7 тэрбум ам.доллаар өсөж, төгрөгийн ам.долларт харьцах ханш оны эхнээс 2 хувиар суларлаа.

Нүүрсний экспортын орлого буурч, төсвийн орлогын гүйцэтгэл төлөвлөсөн дүнгээс доогуур байна. Нэгдсэн төсвийн орлого 2025 оны эхний улирлын байдлаар 6.1 их наяд төгрөгт болж, өмнөх оны мөн үеэс 1.2 их наяд төгрөгөөр буурав. Нүүрсний хилийн дундаж үнэ өмнөх оны мөн үеэс 39.9 хувиар, экспортын тоо хэмжээ 3.3 хувиар буурсан нь төсвийн голлох орлогуудад сөргөөр нөлөөлсөн байна. Төсвийн нийт зарлага 6.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.2 хувиар тэлэхэд урсгал зарлагын өсөлт, тэр дундаа төрийн албан хаагчдын цалин, нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэврийн хэмжээг инфляцын түвшинтэй уялдуулан нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлсөн байна.

Инфляц төв банкны зорилтот түвшнээс өндөр хадгалагдав. Инфляц 2025 оны эхний улиралд төв банкны зорилтот түвшнээс өндөр хадгалагдаж, улирлын эцэст 9.1 хувьд хүрлээ. Гадаад валютын орлогын бууралтаас үүдэлтэйгээр мөнгөний нийлүүлэлтийн хурд саарсан хэдий ч дотоод зээлийн өсөлт өндөр хэвээр хадгалагдлаа. Төв банкнаас мөнгөний бодлогын хүүг 2 нэгж хувиар нэмэгдүүлж 12 хувьд хүргэлээ.